



2024 ОНЫ 12 САРЫН 1

ТННЭ НООС НООЛУУРЫН СТАНДАРТ

ХУВИЛБАР 1.0



ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

Мэдэгдэл

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (цаашид ТННЭ гэх)-ийн ноос ноолуурын стандарт болон бусад баримт бичгүүд, тэдгээрт иш татсан мэдээллийн эх сурвалжуудын нарийвчлал, бүрэн бүтэн байдалд бид баталгаа, тайлбар, нотолгоо гаргахгүй болно. Энэхүү стандарт нь дэлхий дахиныг хамарсан, үндэсний эсвэл орон нутгийн засаг захиргаанаас гаргасан шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журам, захирамж болон бусад албан ёсны баримт бичгүүдийн шаардлагыг орлох, зөрчих болон өөрчлөх зорилго агуулаагүй болно. ТННЭ-ийн ноос ноолуурын стандартыг сайн дурын үндсэн дээр мөрдлөг болгох бөгөөд ТННЭ болон ТННЭ-ийн гишүүд, оролцогч талуудын өмнө хүлээх хуулийн аливаа эрх, үүрэг оноох зорилгогүй. Энэхүү стандартыг мөрдлөг болгодоггүй хэрэглэгчдэд ТННЭ болон ТННЭ-ийн гишүүд, оролцогч талуудын эсрэг чиглэсэн аливаа арга хэмжээ авах хууль ёсны шалтгаан байхгүй.

ТННЭ-ийн тухай

ТННЭ нь малчид, үйлдвэрлэгчдээс эхлээд жижиглэн худалдаа эрхлэгчид хүртэлх ноос ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд орж ажилладаг ашгийн төлөө бус, олон улсын байгууллага юм. Бидний алсын хараа бол байгаль орчинд ээлтэй, мал амьтдын тав тухтай байх орчныг хангасан, малчдын баталгаат амьжиргааг дэмжсэн, хариуцлагатай, оролцоот, олон улсын ноос ноолуурын салбарыг бий болгох. ТННЭ-ийн Ноос Ноолуурын Стандарт нь таван үндсэн зарчмаас бүрдэж байна. Үүнд, i) үр дүнтэй удирдлага, ii) зохистой хөдөлмөр эрхлэлт, iii) биологийн олон янз байдал ба газар ашиглалт, iv) ямааны тавлаг байдал болон v) ноос ноолуурын чанарын сайжруулалт багтана.

Стандартын тухай

ТННЭ Ноос Ноолуурын Стандарт нь ТННЭ-ийн зүгээс тодорхойлсон ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шилдэг туршлага юм. Тус стандарт нь норматив баримт бичиг бөгөөд ТННЭ нь [Стандарт Тохируулах Журам](#)-ын дагуу өөрчлөгдөн буй хэрэгцээ, шинээр гарч ирж буй шилдэг туршлагуудад үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. ТННЭ-ийн албан ёсны хэл нь Англи хэл байна. Орчуулсан баримт бичгүүдэд тодруулга шаардлагатай бол Англи хэл дээрх эх хувийг лавлагаа болгох хэрэгтэй. Таны ашиглаж буй хувилбар хамгийн сүүлчийн хувилбар мөн эсэхийг нягталж үзнэ үү. ТННЭ-ийн вэбсайт дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын хувилбар байршсан байх болно.

Стандарттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг [Стандартын ажлын удирдамж](#)-аас авах боломжтой.

Стандартад хамаарах ноос ноолуурууд

Энэхүү стандарт нь доор дурдсан ноос ноолуурын малд хамаарна:

- Ноолуурын ямаа

Иш татсан баримт бичиг, материалууд

ТННЭ-ийн бусад баримт бичгүүд

- [ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт](#)
- [ТННЭ Цэвэр Ноос Ноолуур Боловсруулах Стандарт](#)
- [Брэнд Таниулах Удирдамж](#)
- [ТННЭ Баталгааны Гарын Авлага](#)
- [ТННЭ Тайлбар Толь](#)
- [ТННЭ Стандарт Тохируулах Журам](#)

ТННЭ-ийн вэб холбоосууд

- [ТННЭ – Тохирлын Үнэлгээний Байгууллагууд](#)
- [ТННЭ Гүйлгээний Бүртгэл Тайлангийн Сайт](#)

Үйлдвэрлэгч орнуудад зориулсан удирдамж

Тус стандартын нэг хэсэг нь ноос ноолуур үйлдвэрлэгч зарим оронд тусгайлан зориулсан удирдамжууд юм. Тэдгээр нь ямар нэг дүрэм эсвэл стандарт биш боловч сайн туршлагууд дээр суурилсан зарим норматив шаардлагуудыг давтаж, бататгаж, тодотгож болно.

[ТННЭ-ийн вэбсайт](#) дээр байрлуулсан Үйлдвэрлэгч орнуудад зориулсан удирдамж баримт бичгүүдийг үзэх холбоос.

Бидэнтэй нэгдэх

“ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолуурын үйлдвэрлэл, худалдаа эрхлэхийн тулд та энд танилцуулж буй стандартын дагуу гэрчилгээ авах хэрэгтэй ба гуравдагч тал буюу аудитын байгууллагаас дүгнэлт гаргуулсан байна. Та гэрчилгээ авахын ашиг тус, хаанаас хэрхэн эхлэх талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидний бэлтгэсэн “[Гэрчилгээ авах](#)” заавар зөвлөгөөнүүдтэй танилцана уу.



Нэмэлт, өөрчлөлт

Энэхүү стандарт нь ТННЭ-ийн бүтээл, санаачилга бөгөөд аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийг ТННЭ хариуцна. Тус стандартын загвар болон хэрэгжүүлэлт эсвэл ТННЭ-ийн хэрэгжүүлдэг аливаа хөтөлбөр, стандартын талаарх санал, сэтгэгдлийг [ТННЭ-ийн нээлттэй хэлэлцүүлгийн портал](#)-аар дамжуулан илгээнэ үү. Энэхүү баримт бичгийг өмнөх хувилбар нь хэвлэгдсэнээс хойш 5 жилийн дотор хянаж, шинэчлэх ба энэ хугацаанд илгээсэн бүх санал асуудлыг анхааралтай авч үзэх болно.

Хүчин төгөлдөр болох хугацаа

2025 оны 4 сарын 1-ний өдрөөс хойш “ТННЭ-ээр Баталгаажсан” бүтээгдэхүүнийг борлуулахтай холбоотой мэдэгдэл гаргах хүсэлтэй боловч ТННЭ Ноолуурын стандартын хувилбар 1.1 эсвэл түүнээс өмнөх аль нэг хувилбарын дагуу гэрчилгээ аваагүй аливаа аж ахуйн нэгж нь 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн энэхүү хувилбар буюу ТННЭ Ноос ноолуурын стандартын дагуу гэрчилгээ авсан байна.

ТННЭ Ноолуурын стандартын хувилбар 1.1 эсвэл өмнөх аль нэг хувилбарын дагуу гэрчилгээ авсан аливаа аж ахуйн нэгж нь 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс хойш “ТННЭ-ээр Баталгаажсан” бүтээгдэхүүнийг борлуулахтай холбоотой мэдэгдлийг үргэлжлүүлэн гаргах хүсэлтэй хэвээр байвал 2025 оны 10 сарын 1-ний өдрөөр хүчин төгөлдөр байгаа гэрчилгээнийхээ хугацааг дуусахаас өмнө энэхүү хувилбар болох ТННЭ Ноос ноолуурын стандартын дагуу гэрчилгээ авсан байна.

Энэхүү баримт бичиг нийтлэгдсэн өдрөөс эхлэн аж ахуйн нэгжүүд гэрчилгээ авах ажлаа эхлүүлж болно.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Хувилбар	Агуулга	Оруулсан засвар	Огноо
1.0	ТННЭ Ноолуурын стандартын 1.1 хувилбар болон өмнөх хувилбаруудыг орлуулав.	ТННЭ Ноос ноолуурын стандарт, хувилбар 1.0: Нэмэлт, өөрчлөлтийн хураангуй	01/12/2024

Энэхүү баримт бичигт шаардлага, зөвлөмж, зөвшөөрөл, боломж болон чадавхыг илэрхийлэхэд дараах үг хэллэгийг ашигласан болно:

- “ёстой, байх, -на⁴” гэсэн нь шаардлагыг заана;
- “хэрэгтэй” гэсэн нь зөвлөмжийг заана;
- “болно” гэсэн нь зөвшөөрлийг заана;
- “боломжтой” гэсэн нь боломж эсвэл чадавхыг заана;
- “нотлох” эсвэл “нотлогдсон” эсвэл “зайлшгүй” гэсэн нь тухайн аж ахуйн нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нь зөвтгөх шалтгаантай гэдгийг тохирлын үнэлгээний байгууллагад нотолж, стандартад заасан шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэлтэй болохыг илтгэнэ.
- гэсэн тэмдэгт нь “удирдамж” болохыг заана. Удирдамж нь стандарт заахгүй боловч зохих шаардлагуудыг давтах, бататгах, эсвэл тодруулж болно.

Хамрах хүрээ ба гэрчилгээжүүлэлт

1. Хамрах хүрээний шаардлагууд

- 1.1 “ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолуурын бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аливаа аж ахуйн нэгжүүд “ТННЭ-ээр Баталгаажсан” бүтээгдэхүүний худалдаа, шошго, боловсруулалттай холбоотой мэдэгдэл гаргахаас өмнө энэхүү ТННЭ Ноос ноолуурын стандартын дагуу гэрчилгээ авсан эсвэл хүчин төгөлдөр хэвээр байгаа өмнөх стандартыг мөрдөж ТННЭ-ээр хүлээн зөвшөөрөгдөж, итгэмжлэгдсэн гуравдагч тал буюу тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-аас гэрчилгээ авсан байх **ёстой**.

■ Энэ баримт бичигт тусгагдсан “аж ахуйн нэгж”, “биет байршил” болон бусад нэр томъёоны тодорхойлолтыг ТННЭ Тайлбар Толиос харна уу.

■ Тохирлын гэрчилгээ нь зөвхөн нэг төрлийн бүтээгдэхүүн (ноос эсвэл ноолуур, харгалзах мал)-д үйлчилнэ. “ТННЭ-ээр Баталгаажсан” нэгээс олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гэрчилгээ авах хүсэлтэй байвал тус бүрд нь нэмж гэрчилгээ авах хэрэгтэй. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл ТННЭ Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлагатай танилцана уу.

- 1.2 Энэхүү стандартын аль нэг шаардлага тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй улсын хуультай зөрчилдсөн тохиолдолд тухайн улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийг нэн түрүүнд **хэрэгжүүлнэ**.

■ Энэ заалт үйл ажиллагаа явуулдаг улсынхаа харьяаллаас гадна үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид хамаарахгүй.

- 1.3 Энэхүү стандартын шаардлагыг хангаж гэрчилгээ авах, эсвэл одоо байгаа гэрчилгээгээ үргэлжлүүлэн эзэмших хүсэлтэй аж ахуйн нэгжүүд “ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт”-ын хамгийн сүүлийн хувилбарын дагуу, эсвэл хүчин төгөлдөр хэвээр байгаа өмнөх стандартыг мөрдлөг болгож гэрчилгээ авсан **байна**.

■ Холбогдох бүх стандартуудын шаардлагыг хангасан борлуулагчийн бүтээгдэхүүнийг “ТННЭ-ээр Баталгаажсан” гэж үзнэ.

2. Гэрчилгээний шаардлагууд

- 2.1 Аж ахуйн нэгж нь энэхүү стандартын бүх шаардлагуудыг хангасан байх **ёстой**.

■ “ёстой, байх, на⁴” гэсэн нь шаардлагыг заана. Энд тусгагдсан бүх шаардлагуудыг хангасан аж ахуйн нэгжийг “ТННЭ-ээр Баталгаажсан” гэж үзнэ.

- 2.2 Аж ахуйн нэгж нь шаардлагуудаас гадна сайжруулах үзүүлэлтүүдийг мөрдлөг болгож **болно**.

■ ‘болно’ гэсэн нь сайжруулах үзүүлэлтийг заана. Стандартад тусгагдсан шаардлагуудаас гадна эдгээр сайжруулах шаардлагуудыг хангаж чадсан аж ахуйн нэгжийг “ТННЭ-ээр Баталгаажсан” гэж үзэх бөгөөд ноос ноолуурын үйлдвэрлэлд “Шилдэг Туршлага” хэрэгжүүлэгч гэсэн мэдэгдэл гаргах боломжтой болно.

Үр дүнтэй удирдлага

3. Аж ахуйн нэгжийн бүтэц

3.1 Аж ахуйн нэгж нь удирдлагын оффистой **байна**.

■ Аж ахуйн нэгж нь тохирлын гэрчилгээг эзэмшигч, хариуцагч байгууллага бөгөөд тохирлын гэрчилгээнд хамаарах бүх үйл ажиллагаанууд стандартын шаардлагуудыг хангаж байгаад анхаарна. Аж ахуйн нэгж нь хамтран үйлдвэрлэгч, бүтээгдэхүүн худалдан авагч, түүхий эд бэлтгэлээс эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нэгдсэн компани, эсвэл дангаараа үйл ажиллагаа явуулдаг бие даасан үйлдвэрлэгч байж болно.

■ Удирдлагын оффис заавал биет оффис байх шаардлагагүй.

3.2 Аж ахуйн нэгж нь “ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолууран бүтээгдэхүүн хурааж авдаг нэг болон түүнээс дээш тооны биет байршилтай **байна**.

■ Биет байршил гэдэгт голдуу хувийн фермүүд эсвэл малчин өрхийг авч үзнэ.

3.3 Аж ахуйн нэгж нь удирдлагын алба нь байрлах тухайн улсад харьяалалтай хуулийн этгээд эсвэл хувь хүн **байна**.

3.4 Аж ахуйн нэгж нь энэхүү стандартын шаардлагуудыг хангах үүднээс тохирлын гэрчилгээнд тусгагдсан биет байршил бүрдээ чиг үүргийг нь тусгасан гэрээ байгуулсан **байна**.

■ Тус гэрээ нь бичгээр үйлдсэн эсвэл аман хэлбэрээр байж болох бөгөөд гэрээний талууд харилцан ойлголцож, тохиролцсон байх ёстой.

■ Аж ахуйн нэгжийн аль нэг биет байршилд энэхүү стандартын шаардлагатай үл нийцэх тохиолдол гарвал бусад бүх биет байршилд үл нийцэл үүссэн гэж үзнэ. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгж болон үйл ажиллагаа явуулж буй бүх биет байршлууд хооронд нягт хамааралтай байх буюу аль аль талдаа хүлээсэн үүрэг, хариуцлагатай байна гэсэн үг юм.

3.5 Аж ахуйн нэгж нь энэхүү стандартын биелэлтийг хангуулах үүрэг хүлээсэн удирдлагын төлөөллийг томилсон **байна**.

■ Тус төлөөлөл нь “ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт”-ын биелэлтийг хангуулах үүрэг хүлээсэн төлөөлөгч байж болно.

3.6 Аж ахуйн нэгж нь удирдлагын төлөөлөгчийн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг ТҮБ болон ТННЭ-д ажлын 20 хоногт багтаан **мэдэгдэнэ**.

■ Мэдэгдлийг ТННЭ-д дараах хаягаар ирүүлнэ: standards@sustainablefibre.org.

4. Сургалт

4.1 Аж ахуйн нэгж нь биет байршил бүрдээ хамгийн багадаа жилд нэг удаа дараах чиглэлээр сургалт санал **болгоно**:

- a) Энэхүү стандартын шаардлагууд, тэдгээрийг аж ахуйн нэгж болон биет байршлууд хэрхэн хэрэгжүүлэх тухай;
- b) Тухайн биет байршил байршиж буй улсад зориулсан “ТННЭ Үйлдвэрлэгч орнуудад зориулсан удирдамж”-ын тухай;
- c) Тухайн аж ахуйн нэгжийн гэрчилгээ авахдаа мөрдлөг болгосон “ТННЭ Мөшгөлтийн тогтолцооны стандарт”-ын хувилбарт тусгагдсан шаардлагууд.

■ Аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах шаардлагагүй боловч биет байршлууддаа сургалт зохион байгуулагдах боломжтой байхад анхаарна. Үүнд аж ахуйн нэгж нь сургалт зохион байгуулах боломжийг судлах, биет байршлуудыг сургалтын талаарх мэдээллээр хангах гэсэн үүрэгтэй байна.

■ ТННЭ болон тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг хамтрагч байгууллагуудын зүгээс тогтмол сургалт санал болгодог.

4.1.1 Сургалт явагдах хэл болон сургалтын хэлбэр нь биет байршлуудад хүртээмжтэй байх **ёстой**.

4.1.2 Аж ахуйн нэгж нь сургалтад өөрсдийн биет байршлуудаас нэг ба түүнээс дээш хүнийг хамруулж **болно**.

5. Аюул

5.1 Биет байршлууд нь доор дурдсан материал/бүтээгдэхүүнийг зөвхөн үйлдвэрлэгчийн зааврын дагуу ашиглах эсвэл устгах **ёстой**:

a) тоног төхөөрөмж;

b) эм, тариа;

■ үүнд вакцин хамаарна.

c) хортон шавж устгалын бодис (пестицид);

d) бордоо;

e) бусад бүх төрлийн аюултай бодисууд.

5.2 Аж ахуйн нэгж нь хортон шавж устгалын бодис, бордоо болон бусад аюултай бодисуудыг ашигласан биет байршлуудад бараа материалын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас зэргийг багтаасан үйлдвэрлэгчийн заавар байгаа эсэхэд хяналт **тавина**.

5.2.1 Биет байршлууд нь эдгээр бодисуудыг ашигласан буюу тэдгээртэй ажилласан бүх ажилчдад тухайн бодисуудын хэрэглээнээс үүдэх эрсдэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ойлгомжтой, сайтар таниулах **ёстой**.

6. Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ

6.1 Аж ахуйн нэгж нь доор дурдсан бүртгэлүүдийг аж ахуйн нэгжийн хэмжээнд, мөн бүх биет байршлуудынхаа хүрээнд үнэн зөв, бүрэн бүтэн, хамгийн сүүлчийн байдлаар цуглуулж, тогтмол **хөтөлнө**:

a) Биет байршил бүрийн ашигласан хортон шавж устгалын бодис, бордоо болон бусад бүх аюултай бодисуудын бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;

b) Гэрээт хөлсний ажилтан ажиллуулсан биет байршлуудын бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;

■ Тодруулбал, гэрээт ажилчин гэдэгт биет байршил дахь малчин өрхийн гишүүн биш хүнийг хэлнэ.

c) Мэдээлсэн болон зохион байгуулсан сургалтын тоо, бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;

d) Биет байршил бүрээс сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо, бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;

- e) Энэхүү стандартын шалгуурууд болон сайжруулах үзүүлэлтүүдийг хангах үүднээс аж ахуй нэгжийн авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - f) Бие байршлуудын өмнөх жил ашигласан газрын бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - g) Газар эзэмших эрх болон байгалийн баялагтай холбоотой зөрчил, гомдлууд, тэдгээрийг хэрхэн шийдсэн тухай үр дүнгийн бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - h) Аж ахуйн нэгжийн борлуулсан ноос ноолуурын бүртгэл. Үүнд борлуулсан бүтээгдэхүүний үнэ болон бусад худалдааны нөхцөлүүдийг тусгасан байна. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - i) Биет байршлууд дээр хийгдсэн худалдан авалт/төлбөрийн бүртгэл. Үүнд үнэ болон ноос ноолуурын худалдаатай холбоотой бусад нөхцөлүүдийг тусгасан байна. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - j) Аж ахуйн нэгж эсвэл түүний биет байршлын авсан зээлийн бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
-  Энэ бүртгэл нь “ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт”-ын дагуу гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн хангах шаардлагууд дээр нэмэгдэж орсон.
- 6.2 Аж ахуйн нэгж нь доор дурдсан бүртгэлүүдийг аж ахуйн нэгжийн хүрээнд, мөн бүх биет байршлууд дээрээ үнэн зөв, бүрэн бүтэн, хамгийн сүүлчийн байдлаар цуглуулж, тогтмол хөтөлж **болно**:
-  Дараах жагсаалтад байгаа үзүүлэлт тус бүрийг тогтмол сайжруулалтыг хангахад чиглэгдсэн тусдаа сайжруулах үзүүлэлт гэж үзнэ.
- a) Биет байршлын түвшинд ноос ноолуурын малын гарал үүслийн бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - b) Биет байршлын түвшинд өмнөх жилд хэрэглэсэн аливаа эмчилгээний бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - c) Биет байршлын түвшинд ноос ноолуурын малын хорогдол, гарзын бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - d) Биет байршлын түвшинд ноос ноолуурын малын өвчлөлийн бүртгэл. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх;
 - e) Биет байршлын түвшинд мал төллөх үед хүний оролцоо, тусламж авсан байдал. Бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх.
-  Аж ахуйн нэгж нь засгийн газар эсвэл орон нутгийн мал эмнэлгийн цуглуулсан бүртгэлд хандах эрхтэй тохиолдолд давхар бүртгэл хөтлөх шаардлагагүй.
-  Хүний оролцоо тусламж гэдэгт мэс заслын буюу кесар хагалгаа багтана.
- 6.3 Аж ахуйн нэгж нь хөтөлсөн бүртгэлүүдийг хамгийн багадаа 5 жил **хадгална**.
-  Энэ нь “ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт”-ын дагуу гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн хангах шаардлагууд дээр нэмэгдэж орсон болно.
-  Бүх бүртгэлүүд нууцлалын чанартай байх бөгөөд ашиг олох зорилгоор ашиглагдахгүй.
-  Үүнд гэрчилгээ авснаас хойш хийгдсэн бүртгэлүүд хамаарах ба гэрчилгээ авахаас өмнөх үеийн 10 жилийн бүртгэлийг үзүүлэх шаардлагагүй.

- 6.4 Аж ахуйн нэгж нь биет байршил болгонд малын хорогдлын хэмжээг үнэлж, хэвийн бус хэт өндөр хорогдолтой байгаа байршлуудад зохих арга хэмжээг авч **болно**.
- 6.5 Аж ахуйн нэгж нь бие байршил болгонд мал төллөх үед хүний оролцоо, тусламж хэр зэрэг байсныг үнэлж, хэвийн бус хэт өндөр хүний хамааралтай байршлуудад зохих арга хэмжээг авч **болно**.

 Хүний оролцоо тусламж гэдэгт мэс заслын буюу кесар хагалгаа багтана.

7. Тогтмол сайжруулалт

- 7.1 Дахин үнэлгээний үеэр аж ахуйн нэгж нь сүүлийн үнэлгээний үеэр хангаж чадаагүй байсан гурван сайжруулах үзүүлэлтийг хангасан гэдгээ харуулах **ёстой**. Мөн сүүлийн үнэлгээний үеэр хангасан байсан бүх сайжруулах үзүүлэлтүүдээ үргэлжлүүлэн хангаж байгаа гэдгээ харуулах **ёстой**.

 Зарим сайжруулах үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдалтай хамааралтай байх тул нөхцөлт шинж чанартай байна. Аль нэг сайжруулах үзүүлэлт тухайн аж ахуйн нэгжид хамааралгүй байх тохиолдолд тогтмол сайжруулалтыг илтгэхэд ашиглагдахгүй.

 Аж ахуйн нэгжийн бүх биет байршлууд шаардлагаас чөлөөлөгдөх эрхтэй байх тохиолдолд тогтмол сайжруулалтыг хангах эрмэлзлээ илэрхийлж аж ахуйн нэгж нь тухайн шаардлагаас чөлөөлөгдөхөөс татгалзаж болно.

- 7.2 Аж ахуйн нэгж нь дараагийн дахин үнэлгээний үеэр 7.1-д заасныг хэрхэн биелүүлэх тухай тусгасан тогтмол сайжруулалтын төлөвлөгөө гаргасан **байна**.

- 7.3 Энэхүү стандартын 16.11 ба 19.1 заалтаас бусад бүх сайжруулах үзүүлэлтийг хангасан аливаа аж ахуйн нэгж 7.1 ба 7.2 заалтаас чөлөөлөгдөнө.

 Гэсэн хэдий ч аж ахуйн нэгж нь “ТННЭ Шилдэг Туршлага” хэрэгжүүлэгч гэсэн өргөмжлөлийг хүртэхээс өмнө бүх сайжруулах үзүүлэлтийг хангасан байх хэрэгтэй. Үүнээс үзэхэд аж үйлдвэрийн ферм/хөдөө аж ахуйн системийг “ТННЭ Шилдэг Туршлага” гэж үзэх боломжгүй юм.

- 7.4 Аж ахуйн нэгж нь биет байршлуудынхаа ашиглаж буй газрыг хамарсан нэг ба түүнээс олон бэлчээрийн менежментийн төлөвлөгөө (БМТ)-г **дагаж мөрдөнө**. Үүнд дараах мэдээлэл багтана:

- a) Аж ахуйн нэгжийн эрх зүйн статус;
- b) Аж ахуйн нэгжийн биет байршлуудын жагсаалт;
- c) Тухайн газрын ерөнхий менежментийг хариуцсан хүний талаар тодорхой мэдээлэл;
- d) Тухайн газрыг ашигладаг хэрэглэгчдийн жагсаалт.

 БМТ нь энэхүү стандартын “Биологийн олон янз байдал ба газар ашиглалт” хэсэгт тусгагдсан шаардлагуудыг хангах зорилгоор аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн биет байршлууд болон бэлчээр ашиглаж буй бусад хэрэглэгчид хоорондоо хэрхэн хамтарч ажиллахыг тодорхойлдог баримт бичиг болно.

 Аж ахуйн нэгж нь тухайн газрын менежментийг бүрэн хариуцдаггүй тохиолдолд тухайн газрыг бүрэн хариуцдаг менежерийн боловсруулсан БМТ-г авч ашиглахыг илүүд үзэж болно. Тухайн БМТ нь энэхүү стандартын “Биологийн олон янз байдал ба газар ашиглалт” хэсэгт тусгагдсан

шаардлагуудтай бүрэн нийцэхгүй байж болох юм. Энэ тохиолдолд аж ахуйн нэгж нь стандартын шаардлагуудтай нийцүүлэх бүх боломжийг эрэлхийлнэ.

■ Тухайн аж ахуйн нэгж ондоо бэлчээр газар хариуцагч менежерүүд бүхий, олон байршилд үйл ажиллагаа явуулдаг биет байршилтай тохиолдолд бие байршлууд нь үйл ажиллагаа явуулдаг бүс нутаг бүрд хамаарах БМТ-г дагаж мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл биет байршлууд бүр ондоо БМТ-г хэрэгжүүлж байж болно.

■ БМТ байхгүй тохиолдолд аж ахуйн нэгж нь өөрсдийн БМТ-г боловсруулна.

- 7.4.1 Аж ахуйн нэгж нь бүх бие байршлуудаа БМТ-ний аливаа боловсруулалтад оролцох бодит боломжоор **хангана**.
- 7.4.2 Аж ахуйн нэгж нь БМТ-г боловсруулахдаа өөрсдийн харьяалалд байдаггүй бусад газар ашиглагчдын газрын ашиглалтыг харгалзан **үзнэ**.
- 7.4.3 Аж ахуйн нэгж нь БМТ-д хэрэгжилтийн хугацааг тусгасан **байна**.
- 7.4.4 Аж ахуйн нэгж нь БМТ-д жил бүр хийгдэх мониторинг, үнэлгээ, сургалт (МҮС)-ын төлөвлөгөөг тусгаж **болно**.
- 7.4.5 Аж ахуйн нэгж нь БМТ нь тухайн газар нутагт амьдарч буй нутгийн иргэд, ноос ноолуурын үйлдвэрлэлд гар бие оролцож буй орон нутгийн ажилчид болон бусад ноос ноолуурын үйлдвэрлэлтэй холбоотой ажилладаг хүмүүсийн уламжлалт мэдлэгийг олж илрүүлж, ашиглах боломжтой байхад анхаарч **болно**.
- 7.4.6 Аж ахуйн нэгж нь БМТ-г бүх биет байршлууддаа танилцуулж, мэдээлэл **өгнө**.
- 7.5 Аж ахуйн нэгж нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас өөрчлөгдөж буй цаг агаарын төлөв байдлыг амжилттай даван туулах арга хэмжээ, зохистой дадлыг хэрэгжүүлж **болно**.
- Энэ нь биет байршлууд мал сүргийнхээ тоо толгойг зохистой түвшинд барьж, бие бялдрын хувьд чийрэг шилмэл сүрэг үржүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын төлөв байдлын шилжилтэд дасан зохицох боломжийг олгоно. Энэ заалт нь аж ахуйн нэгжүүдийг өөрсдийн нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах тухай асуудал биш юм.

8. Зохистой газар эзэмшилт

- 8.1 Биет байршил нь ашиглаж буй газраа хуулийн дагуу ашиглаж байгаа гэдгийг нотлох **ёстой**.
- 8.2 Аж ахуйн нэгж нь Уугуул Иргэдийн Эрхийг Хамгаалах НҮБ-ийн тунхаглал болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-н 169-р Конвенцод тодорхойлсны дагуу уугуул иргэдийн зан заншил, соёлыг хүлээн зөвшөөрч, сахин **хамгаална**.
- Үүнд өвөрмөц соёл, экологи, эдийн засаг, шашин шүтлэг, оюун санааны ач холбогдолтой газруудыг таньж мэдэх, хамгаалах зэрэг багтах ба эдгээрээр хязгаарлагдахгүй.
- 8.3 Аж ахуйн нэгж нь өөрсдийн эсвэл биет байршлуудын үйл ажиллагааны улмаас ямар нэг хэмжээгээр уугуул иргэдийн эдийн засаг, хүний эрх, байгаль орчны эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлээс **хамгаална**.
- Уугуул иргэдийг “иргэдийн бүлэг”-ийн нэг төрөл гэж үздэг тул энэ шаардлагыг гаргасан болно.

8.4 Аж ахуйн нэгж эсвэл түүний төлөөллүүд аль аль нь биет байршлуудаас тэдэнд олгосон эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй **байх**.

■ Энэ нь [НҮБ-ийн Глобал гэрээний 10 дахь зарчмаар](#) тодорхойлогдсон авлига, сүрдүүлэг, хээл хахуулийн гэмт хэргээс сэргийлэх зорилготой.

■ Үүнд “ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолуур ба/эсвэл хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн санхүүгийн үр өгөөжийг бүх гишүүн малчдад адил тэгш хүртээх багтана.

Зохистой хөдөлмөр эрхлэлт

9. Хөдөлмөр эрхлэлт

- 9.1 Аж ахуйн нэгж болон тэдгээрийн биет байршлууд нь ОУХБ-ын 29-р конвенцод заасны дагуу албадан болон/эсвэл хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, үүнийг өөгшүүлэн дэмжихгүй **байх**.
- Үүнд ОУХБ-аас тодорхойлсон албадан хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд багтана.
 - Хөдөлмөрийн гэрээний нөхцөлөөс гаднах аливаа ажил нэмэлт буюу илүү цагийн ажилд тооцогдох бөгөөд тухайн ажилтан нэмэлт цалин урамшуулах авах **ёстой**.
- 9.1.1 Ажилтан ажиллуулдаггүй биет байршлууд энэхүү шаардлагаас чөлөөлөгдөнө.
- 9.2 Аж ахуйн нэгж болон тэдгээрийн биет байршлууд нь ОУХБ-ын 111-р конвенцод заасны дагуу ялгаварлан гадуурхалтыг дэмжихгүй **байх**.
- 9.3 Аж ахуйн нэгж болон тэдгээрийн биет байршлууд нь ОУХБ-ын 90-р конвенцод заасны дагуу хэн нэгэнд хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэхгүй **байх**.
- 9.4 Аж ахуйн нэгж болон биет байршлуудад ажиллаж буй бүх ажилчид хөдөлмөрийн гэрээтэй байх **ёстой** ба гэрээнд ажлын нөхцөл хэвийн, урамшуулалт цалин хөлсний нөхцөл байгаа болохыг тусгасан **байна**.
- Хөдөлмөрийн гэрээ нь бичгийн эсвэл аман хэлбэрээр байж болох ч хоёр тал гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож, зөвшөөрсөн байна.
 - Хэвийн ажлын нөхцөл гэдэг нь гэрээнд тусгагдсан тогтмол ажлын цаг болон гүйцэтгэх ёстой ажил үүргийг хэлнэ.
 - Зохистой гэж үзвэл хөдөлмөрийн гэрээнд малд гарз гарсан тохиолдолд ямар үед ажилтан санхүүгийн хувьд хариуцлага хүлээх ёстойг, мөн үүнийг хэрхэн шийдэх талаар тодорхой тайлбарласан **байх**.
- 9.5 Аж ахуйн нэгж болон түүний биет байршлуудад ажиллаж буй бүх гэрээт ажилчдад тухайн улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эсвэл хамтын тохиролцоогоор тогтоосон цалингийн аль өндөр дүнгээр нь цалин хөлсийг **олгоно**.
- 9.6 Аж ахуйн нэгж нь ажилтны хүйс, ажлын байрны статус, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа, нас болон бусад хүчин зүйлээс үл хамааран тухайн аж ахуйн нэгж ба түүний биет байршлуудад ажиллаж буй гэрээт ажилчдад ижил хэмжээний хөдөлмөрийн хөлсийг **олгоно**.
- Энэ нь тухайн аж ахуйн нэгж болон түүний биет байршлуудад цалин хөлс ижил байх хэрэгтэйг илтгэх боловч бусад бүх биет байршлуудад ижил байна гэсэн үг биш юм.
- 9.7 Аж ахуйн нэгж болон биет байршлууд нь ОУХБ-ын 182 дугаар конвенц болон 190 дүгээр зөвлөмжид заасны дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр ба/эсвэл хүүхдийг аюултай хөдөлмөр эрхлүүлэхгүй байх **ёстой**.
- 9.8 Аж ахуйн нэгж болон түүний биет байршлууд нь сургуулийн насны хүүхдийн мал маллах ухаанд суралцах цаг нь зөвхөн хичээлийн бус цагаар байхад **анхаарна**.

10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- 10.1 Биет байршил нь ажилчдын эрүүл мэнд болон аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй ажлын байрыг олж тогтоох, эрүүл мэнд, аюулгүй байдал учруулж болзошгүй аливаа аюул эрсдэлийг бууруулах **ёстой**.
- 10.2 Биет байршил нь ажилчдын эрүүл мэнд болон аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй нөхцөлүүдийг өртөж болзошгүй бүх ажилчдад мэдээлэх **ёстой**. Учирч болох аливаа эрсдэлийг бууруулах нь эрсдэлд байгаа ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцсан менежерийн үүрэг байна.
- 10.3 Биет байршил нь машин механизм ашиглагдаж байгаа тохиолдолд тухайн механизмыг ажиллуулж буй ажилчид аюулгүй ажиллагааны зааварчилгаатай уншиж танилцсан эсэхэд хяналт тавьж, зааварчилгааг биед ойр **байлгана**.
- 10.4 Биет байршил нь машин механизм ашиглагдаж байгаа тохиолдолд машин механизмын эвдрэл, эд ангийн доголдол гарах боломжийг хамгийн бага байлгахын тулд засвар үйлчилгээг хийж, зөв зохистой хадгалж, **арчилна**.
- 10.5 Биет байршил нь ажилчныг зохих хувийн хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй **хангана**.
- 10.6 Биет байршил нь ажилчдыг ундны ус болон угаалга хийхэд тохиромжтой аюулгүй тоноглол, хэрэгслээр **хангана**.
- 10.7 Биет байршил нь галын аюулаас хамгаалах хэрэгсэл, галын дохиоллоор **хангана**.
- 10.7.1 Ажилчид ажиллуулдаггүй буюу биет байршил дээр байршдаг хүнгүй биет байршлууд галын дохиололтой байх шаардлагаас чөлөөлөгдөнө.
- 10.8 Биет байршил нь зөвтгөх үндэслэл байгүй л бол дараах зүйлсээр тогтмол **хангана**:
- a) Ажилчдын тоо, хүйсийн онцлогт тохирсон цэвэр, ариун цэврийн шаардлага хангасан угаалга хийх болон ариун цэврийн байгууламж;
 - b) Ослын үеийн гарц тодорхой биш газруудад тодорхой тэмдэглэгээтэй, түгжээгүй, чөлөөтэй нээгдэх гарц, замууд;
 - c) Жирэмсэн эмэгтэйчүүдэд тохиромжтой нөхцөл, эсвэл тохиромжгүй ажлын байранд зохих зохицуулалт хийх.
- 10.9 Биет байршил нь дараах зүйлсээр хангаж **болно**:
- a) Ажилчдын хооллох, хоол хүнсээ хадгалах цэвэр сууц, байгууламжууд;
 - b) Хүүхэд асрах, хөхүүлэх байгууламжууд.
- 10.9.1 Хөлсөөр ажилладаг ажилчингүй биет байршлууд эдгээр сайжруулах үзүүлэлтүүдээс чөлөөлөгдөнө.
- 10.10 Биет байршлууд нь ажилчдынхаа байгаль орчноос үүдэлтэй халдварт өвчин тусах эрсдэлийг бууруулах үүднээс тухайн орон нутагт тохирсон арга дадлуудыг хэрэгжүүлж буй эсэхэд аж ахуйн нэгж хяналт **тавина**.

Биологийн олон янз байдал ба газар ашиглалт

11. Бэлчээрлэх малын тоо толгой

- 11.1 Аж ахуйн нэгж нь биет байршлынхаа ашиглаж буй бэлчээр, түүний дотор нөөц бэлчээрийг тодорхойлох **ёстой** ба бэлчээр сэлгэх нүүдэл болон ашиглах хуваарийн талаар тухайн бэлчээрийн ерөнхий менежментийг хариуцаж буй хүнтэй **зөвшилцөнө**.

■ Энэхүү зөвшилцөл нь Бэлчээрийн Менежментийн Төлөвлөгөө (7.4)-д тусгагдсан байх хэрэгтэй.

- 11.2 Аж ахуйн нэгж нь бэлчээрлэх малын тоо толгой тухайн бэлчээрийн даацад тохирсон эсэхэд **анхаарна**.

■ Өөрөөр хэлбэл бэлчээрлэх малын тоо толгойг тогтооход ургамал, амьтдын унаган төрх, төрөл зүйлийн ач холбогдол, газрын төлөв байдал, бэлчээрийн чанар, улирлын нөхцөл, малын төрөл/үүлдэр, бэлчээрийн даац хэтрэх зэрэг асуудлуудыг харгалзан үзнэ гэсэн үг.

12. Хамгаалал ба нөхөн сэргээлт

- 12.1 Аж ахуйн нэгж нь ашиглаж буй газрынхаа байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хадгалан **хамгаална**.
- 12.2 Аж ахуйн нэгж нь биет байршлын ашиглаж буй газрын байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг цаг хугацааны явцад сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж **болно**.
- 12.3 Аж ахуйн нэгж нь биет байршлын ашиглаж буй газрын байгалийн усны голдирол, уст намгархаг цэгүүдийг тогтоох **ёстой**. Мөн биет байршлын явуулж буй үйл ажиллагааны улмаас элэгдэл, бохирдол болон тунадас хуримтлал үүсэж эдгээр усны нөөцөд нөлөөлөхгүй байх арга хэмжээг **авна**.
- 12.4 Аж ахуйн нэгж нь биет байршлын ашиглаж буй газарт байрлах байгалийн усны голдирол, уст намгархаг цэгүүдийг цаг хугацааны явцад сэргээх арга хэмжээ авч **болно**.
- 12.5 Аж ахуйн нэгж ба түүний биет байршил нь ашиглаж буй газартаа харь зүйлийн амьтан, ургамлын төрлийг нутагшуулахгүй байх арга хэмжээ **авна**.
- 12.6 Аж ахуйн нэгж нь биет байршлынхаа ашигладаг газрын муудаж доройтсон хэсгийг таньж **тогтооно**.
- 12.7 Аж ахуйн нэгж нь биет байршлынхаа ашигласан газрын муудаж доройтсон хэсгийг цаг хугацааны явцад сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлж **болно**.
- 12.8 Аж ахуйн нэгж нь биет байршлынхаа ашигладаг газар дахь зэрлэг амьтдын нүүдэллэдэг коридор болон жимийг хаахгүй байгалийн хэвээр нь **байлгана**.
- 12.9 Аж ахуйн нэгж нь биет байршлын эзэмшилд нохой байлгаж, мал сүргийн зэрлэг амьтдад өртөх эрсдэлийг бууруулах орон нутагт тохирсон арга туршлагыг **хэрэгжүүлнэ**.
- 12.10 Аж ахуйн нэгж нь биет байршил нь ашиглаж буй газрынхаа мал сүрэг болон зэрлэг амьтдын тоо толгойд тохирсон амт шимтэй бэлчээрийн нөөцийг сайжруулах, тэр дундаа ургамлын олон янз байдал болон ургамлын бүрхэвчийг нэмэгдүүлэхэд орон нутгийн онцлогт тохирсон арга туршлагыг хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулж **болно**.

- 12.11 Аж ахуйн нэгж нь биет байршил нь ашиглаж буй газартаа хөрсний нягтрал, элэгдлийг багасгах, хөрсний органик бодисын алдагдлыг бууруулахын тулд орон нутгийн онцлогт тохирсон арга, туршлагыг хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулж **болно**.
- 12.12 Аж ахуйн нэгж нь өөрсдийн ба биет байршлуудынхаа үйл ажиллагаа явуулдаг газруудад байгалийн унаган төрх, зэрлэг амьтан, ургамлыг хамгаалахад чухал ач холбогдол бүхий бүсүүдэд мал амьтан бэлчихгүй бүс байгуулж **болно**.
- 13. Байгаль орчны бохирдлоос сэргийлэх**
- 13.1 Биет байршил нь амьтны сэг зэмийг эрүүл ахуйн шаардлагын дагуу устгах **ёстой**.
-  *Сэг зэмээс үүдэлтэй өвчин тараахгүй байхаар устгалыг хийнэ.*
- 13.2 Биет байршил нь тухайн газрыг цаашид бэлчээр, тэжээлийн зорилгоор ашиглах боломжгүй болгох аливаа аюултай бодисыг бэлчээрт хаяж, устгаж **болохгүй**.
-  *Аюултай бодисуудад малын сэг зэм, ашиглагдаагүй эсвэл хугацаа нь дууссан эм, тариа зэрэг химийн, эмнэлгийн болон биологийн хог хаягдал орох ба үүгээр хязгаарлагдахгүй.*
- 13.3 Аж ахуйн нэгж нь аюултай бодисын нөлөөнд өртсөн газрыг цаг хугацааны явцад нөхөн сэргээх арга хэмжээ авч **болно**.
- 13.4 Аж ахуйн нэгж ба түүний биет байршлууд хортон шавжтай тэмцэх тохиолдолд нэн түрүүнд биологийн ба физикийн мөн бусад химийн бус аргуудыг **ашиглана**.
- 13.5 Аж ахуйн нэгж ба түүний биет байршлууд хортон шавжтай тэмцэх пестицидийг зөвхөн хортон шавжийн тархалтын түвшин мал амьтан, бэлчээрт хор хөнөөл учруулах хэмжээнд хүрсэн тохиолдолд **ашиглана**.
- 13.6 Аж ахуйн нэгж ба түүний биет байршлууд пестицидийг хортон шавж түүний эсрэг тэсвэртэй болохооргүй замаар **хэрэглэнэ**.
- 13.7 Аж ахуйн нэгж ба түүний биет байршлууд олон улсын хэмжээнд ашиглахыг хориглосон пестицидийг **хэрэглэхгүй**.
-  *Хориотой пестицидүүд гэдэгт [PAN International Consolidated List of Banned Pesticides](#) -д багтсан бодисуудыг хэлнэ.*

Малын тавлаг байдал

14. Мал маллагаа ба зохистой харьцаа

- 14.1 Биет байршил нь ноос ноолуурын малтай зүй зохистой харьцаж бие махбодод нь зодуур үзүүлэхгүй, айдаст автуулахгүй **байх**.
- Амьтдыг өшиглөх, цохих, бүдэрч унагаах, хашааны хаалгаар хавсарч цохих, шидэх эсвэл өндрөөс унагаах, мөн арьс, үс, сүүл, эвэр, чих, толгой, хүзүү, хойд хөлөөс нь чирэх эсвэл зулгааж өргөхийг хориглоно.
 - Мөн малыг ташуур, мод, чулуу болон цахилгаан хэрэгсэл ашиглан хөөх, цохиж болохгүй.
 - Биет байршил нь ноос ноолуурын малтай харилцан итгэлцлийг бий болгож, сүрэг дотор тайван амгалан, айдас аюулгүй байлгаж, сүргийг зөв арга барилаар маллах ёстой.
 - Ноос ноолуурын мал нь биет байршил дээр ажиллаж буй ажилчидтай тайван, дуулгавартай харьцаж байх хэрэгтэй.
- 14.2 Биет байршил нь төл мал, хээлтэй, гэмтсэн, доголон эсвэл өвчтэй малтай илүү анхаарал, болгоомжтой харьцах **ёстой**.
- 14.3 Биет байршил нь ноос ноолуурын малыг **зайлшгүй** тохиолдолд, шаардлагатай хугацаагаар уях, эсвэл хашаанд түр тусгаарлаж **болно**.
- Малыг уяж, тусгаарлах болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна.
- 14.4 Биет байршил нь ноос ноолуурын малыг дасал болсон сүрэгт нь тогтвортой байлгаж, сүргийн бусад амьтадтай ижилдэх, холбоо үүсгэх боломжийг **бүрдүүлнэ**.
- 14.5 Биет байршил нь үржлийн бус улиралд хээлтүүлэгчийг сүргээс тусгаарлаж **болохгүй**.
- 14.6 Биет байршил нь ноос ноолуурын малыг **зайлшгүй тохиолдлоос** бусад үед тусгаарлалтад байлгаж **болохгүй**.
- Малыг уяж, тусгаарлах болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна. Энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийхийг зөвшөөрөх үндэслэл болно.
- 14.7 Биет байршил нь ноос ноолуурын малыг өдрийн дунд үед амарж байх боломжоор **хангана**.
- Өдрийн дунд үе нь нар эгц өндөрт хүрч, хамгийн хурц байх үе юм.
 - Ноолуурын ямааны хувьд амрах зохимжтой хугацаа нь хамгийн багадаа 2 цаг байна.
- 14.8 Биет байршлуудад цахилгаан хатгуур, цахилгаан имобилизатор (цахилгаан гүйдлээр хөдөлгөөнгүй болгогч төхөөрөмж), болон эдгээртэй адил цахилгаан хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглах **ёсгүй**.
- 14.9 Бие байршлууд нь халуун төмрөөр амьтдыг тамгалахгүй **байх**.

- 14.10 Биет байршил нь амьтдын сэг зэмийг бусад амьтдын хараанаас нэн даруй **холдуулна**.

 *Аж ахуйн нэгж нь сэг зэм устгах төлөвлөгөөг үзүүлэх эсвэл зориулалтын устгалын газартай гэдгээ нотлон үзүүлэх боломжтой байх ёстой.*

15. Ноос ноолуур хураах

- 15.1 Биет байршил нь ноос ноолуур авах ажлыг дадлага туршлагатай хүнд даатгах бөгөөд амьтдад тухгүй байдал үүсгэх, гэмтээж бэртээхээс сэргийлж сайтар бэлтгэсэн багаж хэрэгсэл, арга техник ашиглах **ёстой**.

 *Тухайлбал ноос ноолуур авч байх үед амьтдын арьсыг ахин дахин шархлуулж, гэмтээж байгаа тохиолдолд ашиглаж буй багажын ирийг мохоо болгох эсвэл зөөлөн авах шаардлага гарж болно.*

- 15.2 Биет байршил нь ноос ноолуур авах зорилгоор амьтдын хөдөлгөөнийг хорихдоо тэдгээрийн цусны эргэлтийг хязгаарлахааргүй, өвтгөхгүй, биед нь гэмтэл учруулахгүй байх арга **хэрэглэнэ**.

 *Ноос ноолуур авах ажлыг чадамгай гүйцэтгэж байгаа тохиолдолд, мөн ямаа нь тайван, дөлгөөн байвал ямааг босоо чигээр нь эсвэл хэвтүүлж самнахыг аль алиныг нь зөвшөөрдөг.*

- 15.2.1 Биет байршил нь малыг ноос ноолуур авах зорилгоор түр хөдөлгөөнийг нь хязгаарласан тохиолдолд хараа хяналтгүй орхиж **болохгүй**.

- 15.3 Биет байршил нь малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөргүй цаг агаартай нөхцөлд гадаа, задгай орчинд ноос ноолуурыг **авна**.

 *Цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн, мөн дотор ажил гүйцэтгэх боломжгүй бол ноос ноолуур авах ажлыг хойшлуулах **ёстой**.*

- 15.4 Биет байршил нь ноолуурыг нь авсаны дараа ямааг хүйтэн цаг агаарт гаргалгүй, дааруулахгүй байх арга хэмжээг **авна**.

 *Тухайлбал дөнгөж хяргуулсан малыг тэр даруй задгай бэлчээрт гаргаж болохгүй.*

 *Байр, хашаанд оруулах боломжгүй тохиолдолд хүйтэн цаг агаараас сэргийлэх үүднээс малыг хяргах бус самнах хэрэгтэй.*

- 15.5 Биет байршил нь ноос ноолуур авахаас өмнө дөрвөн цагийн турш малд өвс тэжээл, ус өгөхийг хязгаарлах **ёстой**.

- 15.6 Биет байршил нь анх удаагаа самнуулж буй малыг илүү удаан, болгоомжтой самнана.

 *Энэ нь тухайн амьтныг самнуулах болон/эсвэл хяргуулах үйл ажиллагаанд дасгахад туслах юм.*

- 15.7 Биет байршил нь ноолуур авахад самнах аргыг ашиглах тохиолдолд ноолуурыг зөвхөн ноолуур хөөрч эхлэх үед **авна**.

16. Шим тэжээл ба ус

- 16.1 Биет байршил нь ноос ноолуурын малыг өдөр бүр цэвэр, аюулгүй усаар хангаж, ханатлаа ууж байх нөхцөлийг **бүрдүүлнэ**.

- 16.2 Биет байршил нь ноос ноолуурын малд өгөх өвс тэжээл, усыг зөвхөн **зайлшгүй тохиолдолд**, тодорхой хугацаагаар л **хорино**.

- *Малын өвс тэжээл, усыг хязгаарлах болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна (жишээлбэл ноос ноолуур авахын өмнө). Энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийхийг зөвшөөрөх үндэслэл болно.*
- 16.3 Биет байршил нь ноос ноолуурын малыг муудсан, бохирдсон өвс тэжээлээр **тэжээхгүй байх.**
- *Үүнд өвчтэй малын сэг зэм багтана.*
- 16.4 Биет байршил нь ноос ноолуурын малыг өвс тэжээл идэх, ус уух цэгүүдээр хангаж, бөөгнөрч шахцалдахгүй байхад **анхаарна.**
- 16.5 Биет байршил нь малын эмчийн зааварчилгаагүйгээр эсвэл зайлшгүй шалтгаангүйгээр ноос ноолуурын малыг малын дайвар бүтээгдэхүүнүүд болон загасны гурилаар хооллохгүй **байх.**
- *Малыг дайвар бүтээгдэхүүн, загасны гурилаар хооллох болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна.*
- *Ижил сүргийг өвчтэй малын дайвар бүтээгдэхүүнээр хооллохыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй.*
- 16.6 Биет байршил нь ноос ноолуурын малд өсөлтийг нь дэмжих зорилгоор өсөлтийг тэтгэх даавар, эмчилгээний бус антибиотик хэрэглэх **ёсгүй.**
- 16.7 Биет байршил нь малыг аюултай буюу хортой ургамал идэх боломжгүй байх нөхцөлөөр **хангана.**
- 16.8 Биет байршил нь малыг ямар ч тохиолдолд эцэж турахгүй, ядрахгүй байхад **анхаарна.**
- *Эцэж турахгүй гэдэг нь тухайн ноос ноолуурын мал нь 5 онооноос бүрдэх биеийн байдлын үнэлгээний хэмжүүр (1 нь хэт эцэнхий, 5 нь хэт илүүдэл жинтэй)-ээр 2-оос доош оноогоор үнэлэгдэх ёсгүй болохыг илтгэнэ.*
- 16.9 Бие байршил нь ноос ноолуурын малыг идэш тэжээлээс шалтгаалах өвчнөөр өвчлөхгүй байх нөхцөлөөр **хангана.**
- *Ноолуурын ямааны хувьд дараах багтана. Үүнд энтеротоксеми (enterotoxemia), полиоэнцефаломалази (polioencephalomalacia), хээл тээх үеийн хордлого (pregnancy toxemia), шээсээр кальци алдах (urinary calculi), болон булчин цайх өвчин (white muscle disease) орох бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй.*
- 16.10 Биет байршил нь мал зулгааж идэхэд тохиромжтой бутлаг, сөөглөг ургамал бүхий газарт бэлчээрлэх боломжоор **хангана.**
- *Тэдгээр бут, сөөгийг шинээр тастаж өгч болно.*
- 16.11 Мал амьтад нь авч буй шим тэжээлийнхээ дийлэнх хэсгийг өвслөг ургамлаар дамжуулан авч байгаа эсэхэд биет байршлууд хяналт тавьж **болно.**
- 16.12 Мал амьтдын авч буй шим тэжээлийн дийлэнх хувийг нэмэлт тэжээл эзэлдэг бол тухайн биет байршил нь Тэжээлийн Менежментийн Төлөвлөгөө боловсруулсан **байна.**

- 16.13 Мал амьтад авч буй шим тэжээлийнхээ дийлэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг бол тухайн биет байршил нь идэш тэжээл дэх өвслөг ургамлын эзлэх хувь нь малын хивэх хэрэгцээнд хангалттай байгаа эсэхэд **анхаарна**.
- 16.14 Мал амьтад авч буй шим тэжээлийнхээ дийлэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг тохиолдолд биет байршил нь идэш тэжээлдээ өөрчлөлт оруулахдаа амьтдын хоол боловсруулах эрхтний хямралаас сэргийлэхийн тулд аажмаар буюу хамгийн багадаа хоёр долоо хоногийн турш дасгаж **өөрчилнө**.
- 17. Эмнэлгийн тусламж ба ажиглалт**
- 17.1 Аж ахуйн нэгж нь мэргэшсэн малын эмчийн тусламжтай биет байршлынхаа мал сүргийн тавлаг байдлыг хангаж буй байдал, малын эрүүл мэндийн арчилгаа, эмчилгээний арга техникт нь хяналт тавих зорилгоор жил бүр үнэлгээ хийлгэж **болно**.
- 17.2 Биет байршил нь малыг 24 цаг тутамд хамгийн багадаа нэг удаа ажиглаж, өвчин, гэмтэл болон хэвийн бус зан авир гаргаж буй эсэхийг **шалгана**.
- 17.2.1 Өвчтэй, доголон болон гэмтсэн малд зохих эмчилгээ, арчилгаа үзүүлж, өвс тэжээлээр хангаж, 24 цаг тутамд хамгийн багадаа хоёр удаа **ажиглах**.
- 17.2.2 Өвчин халдварлах эрсдэлтэй тохиолдолд өвчтэй малыг сүргээс тусгаарлах.
-  *Малыг бүрэн тусгаарлахаас зайлсхийх шаардлага хүчинтэй хэвээр болохыг анхаарна уу.*
- 17.3 Ноос ноолуурын мал туурайтай бол биет байршил нь малыг доголохоос урьдчилсан сэргийлж малын туурайг тайрч багасгасан **байх**.
- 17.3.1 Биет байршил нь бүх малынхаа туурайг жилд багадаа хоёр удаа шалгасан байна.
-  *Жилд хоёроос олон удаа туурай тайрч багасгах тохиолдолд гарч болно.*
- 17.4 Биет байршил нь шимэгчийн халдвараас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг авч **хэрэгжүүлнэ**.
- 17.5 Шинээр олж авсан ноос ноолуурын малыг бусад бүх сүрэгт нийлүүлэлгүй багадаа 21 хоног тусгаарлаж, хагас хорио **тавина**.
-  *Тусгаарлалт гэдэг нь мал сүргийг хоорондоо шүргэлцэхээс сэргийлж тусад нь байлгахыг хэлнэ.*
-  *Хагас хорио гэдэг нь тусгаарлалтад байгаа амьтдыг бусад мал сүрэгт харагдахуйц, үнэр, дуу чимээг сонсохуйц зайд тусгаарлахыг хэлнэ.*
- 17.6 Биет байршил нь сүргийн аль нэг гишүүнд хэрэглэсэн аливаа эмчилгээний бодисыг (ургамлын гаралтай эм мөн багтана) **бүртгэж**, эмчилгээний шалтгаан, эмчилгээ хийсэн огноог тодорхой **тэмдэглэнэ**.
- 17.6.1 Биет байршил нь эмчилгээ хийлгэж буй малыг тус бүрд нь бүртгэж **болно**.
- 17.7 Биет байршил нь **зөвтгөх үндэслэлгүйгээр** ноос ноолуурын малыг **хөнгөлөх ёсгүй**.
-  *Малыг хөнгөлөх болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн мал эсвэл сүргийн тавлаг байдлын төлөө (жишээлбэл цус ойртохоос сэргийлэх) эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна.*
- 17.7.1 Биет байршил нь зөвтгөх **үндэслэлгүйгээр** тодорхой нэг тогтоосон наснаас дээш настай ноос ноолуурын малыг **хөнгөлөхгүй**.

- *Малыг хөнгөлөх болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдал эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна.*
 - *Ноолуурын ямааны хувьд хөнгөлөх зохимжтой нас нь 8 долоо хоногтой болсон үе байна.*
- 17.8 Биет байршил нь малыг цэвэрхэн, зориулалтын багаж хэрэгсэл ашиглаж, дадлага туршлагатай хүнээр хөнгөлүүлж, хөнгөлсний дараах амьтдын эрүүл мэнд, эдгэрэлтэд анхаарал тавьж эмчилгээ, арчилгаа **үзүүлнэ**.
- 17.9 Биет байршил нь мал хөнгөлөх үед өвдөлт намдаах эм тариа хэрэглэж **болно**.
- 17.10 Биет байршил нь ноолуурын ямааны үнэр ялгаруулагч тосны булчирхайг авах (de-scenting), эвэр ургалтыг төөнөж зогсоох (disbudding), эвэр тайрах болон молцгийг тайрч авах **ёсгүй**.

18. Нядалгаа

- 18.1 Мал амьтад нь шим тэжээлийнхээ дийлэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг тохиолдолд нэгээс олон мал нэг дор нядалгаанд оруулах, мөн малын тоо толгойг багасгах эсвэл худалдааны мах үйлдвэрлэлийн зорилгоор малыг нядалж байгаа бол биет байршил нь малыг төхөөрөхдөө хурдан хугацаанд ухаан балартуулах аргыг **ашиглах** ба нядалгааны явцад мал мэдээ орж, сэрэхээргүй байх **ёстой**.

 Энэхүү шалгуурын зорилго нь төхөөрөх гэж буй малын өвдөлт болон айдсыг багасгахад оршино.

- 18.1.1 Биет байршил нь малыг төхөөрөхөөс өмнө хурдан хугацаанд ухаан балартуулж **болох** бөгөөд нядалгааны явцад мал мэдээ орж, сэрэхээргүй байх ёстой.
- 18.2 Биет байршил нь мал төхөөрөхөд ямар арга ашиглахаас үл хамааран малыг зөвхөн цэвэрхэн, зориулалтын багажаар, туршлагатай хүнээр **төхөөрүүлнэ**.
- 18.3 Биет байршил нь мал төхөөрөхөд ямар арга ашиглахаас үл хамааран малыг найдвартай хурдан, үр дүнтэй төхөөрөхөд **анхаарна**.
- 18.4 Биет байршил нь төхөөрөх гэж буй малыг төхөөрөх хүртэл нь төхөөрөх гэж буйг мэдэгдэхгүй **байх**.
- 18.5 Биет байршил нь ойр хавьд төхөөрсөн бусад малыг өөрийн мал сүрэгтээ мэдэгдэхгүй **байх**.
-  Энэ нь тухайн мал өөрийг нь төхөөрөх хүртэл бусад малыг төхөөрч байхыг харах, сонсох эсвэл үнэрлэх боломжгүй байх ёстой гэсэн үг. Ингэснээр төхөөрөх гэж буй мал тайван байж, айдас түгшүүргүй байх юм.
- 18.6 Биет байршил нь малыг гадаад улсад нядалгаанд оруулах зориулалтаар худалдахгүй **байх**.

19. Малын байр сууц, хашаа

- 19.1 Биет байршил нь малыг бэлчээрт гаргалгүй бэлчээрлэлтийг хязгаарлах болсон хүндэтгэх шалтгаанаа нотолж **болно**.
-  Малыг бэлчээрт гаргалгүй хязгаарлах болсныг зөвтгөх үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангахын тулд байна. Энэхүү стандартын бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийхийг зөвшөөрөх үндэслэл болно.
- 19.2 Мал ихэнх цагийг сараа эсвэл хаалттай талбайд өнгөрүүлдэг бол тухайн биет байршил нь малыг чөлөөтэй хөдөлгөөн хийх, идээшлэх, тоглоход тохиромжтой орчныг **бүрдүүлнэ**.
-  Ноолуурын ямааны хувьд энэ нь дүнз мод, хожуул, өндөрлөсөн газар эсвэл овоолго зэрэг байна.
-  Тусгаарласан буюу хаалттай талбай гэдэг нь малыг чөлөөтэй хөдлөхөөргүй хязгаарлаж өгсөн орон зайг хэлнэ. Үүнд байр сууц, хашаа, тээвэрлэлтийн машин зэрэг багтах ба эдгээрээр үл хязгаарлагдана.
- 19.3 Мал ихэнх цагийг сараа эсвэл хаалттай талбайд өнгөрүүлдэг бол тухайн биет байршил нь малын тавлаг байдлыг хангах тухай тусгасан төлөвлөгөөтэй **байх** ёстой бөгөөд жилд багадаа нэг удаа **хянан сайжруулна**.

- 19.4 Биет байршил нь ихэнх цагийг хаалттай талбайд өнгөрүүлдэг малд хангалттай зай талбай байгаа эсэхэд **анхаарна**.
-  Ноолуурын ямааны хувьд хангалттай зай талбай гэдэгт нэг ямаанд багадаа 2м.кв зай оногдохыг хэлнэ.
- 19.5 Биет байршил нь ихэнх цагийг хаалттай талбайд өнгөрүүлдэг малд чөлөөтэй хөдөлгөөн хийх боломжтой зай талбайгаар хангана.
-  Энэ нь үндсэн байрнаас гадна нэмэлт талбай болно.
-  Ноолуурын ямааны хувьд хангалттай зай талбай гэдэгт нэг ямаанд багадаа 5м.кв зай оногдохыг хэлнэ.
- 19.6 Биет байршил нь малын байр, хашаа, тээврийн хэрэгсэл, ачих байгууламж зэргийг ашигладаг бол тэдгээр нь малыг гэмтээхгүй, тамирдуулахгүй байх ёстойг бодолцож барьсан, засварлаж торддог **байна**.
- 19.7 Биет байршил нь малын хаалттай талбайг аливаа аюултай хог хаягдал, объектоос ангид, хол **байлгана**.
- 19.8 Биет байршил нь малын байр, хашаа, тээврийн хэрэгсэл, ачих байгууламж зэргийг ашигладаг тохиолдолд тэдгээрийг тааламжгүй, хүчтэй үнэр гаргахгүй байхад **анхаарна**.
-  Энд тавих зорилт бол мал бүрд аммиак буюу шүвтрийн түвшнийг нь 1-2 ppm хүргэхгүй байх, мөн цаг тутамд 10-20 удаа агаар сэлгэж байх.
- 19.9 Биет байршил нь байгалийн бус гэрэл ашиглаж буй тохиолдолд малыг 24 цаг буюу нэг хоногт 16 цагаас дээш хугацаагаар байгалийн бус гэрэлд байлгахгүй байхад **анхаарна**.
- 19.10 Биет байршил нь малыг өдрийн цагаар байгалийн гэрэлд гардаг байх нөхцөлөөр **хангана**.
- 19.11 Мал байрлах байранд шал хийсэн тохиолдолд биет байршил нь мал хэвтэж амрахад тухтай байхад **анхаарна**.
-  Шал зөөлөн, цэвэр, хуурай байх ёстой бөгөөд бетон болон үүнтэй төстэй материалаар хийгдсэн байж болохгүй.
- 19.11.1 Биет байршил нь өвчтэй, гэмтсэн, хээлтэй болон/эсвэл залуу (нэг нас хүрээгүй) малыг завсартай шалан дээр байлгахгүй **байх**.
- 19.12 Биет байршил нь ноос ноолуурын малыг завсартай шалан дээр байлгахаас зайлсхийж **болно**.
- 19.13 Биет байршил нь малын байран дахь нойтон өтөг, бууцыг өдөр бүр цэвэрлэж, **асгана**.
- 20. Саравч**
- 20.1 Биет байршил нь малд цаг агаарын аливаа эрс тэс, ширүүн нөхцөлөөс бүрэн хамгаалах саравч/нөмөртэй хашаа, хамгаалалт барьж **өгнө**.
-  Үүнд хэт халуун эсвэл хэт хүйтэн цаг агаар аль аль нь хамаарна.
-  Саравч/нөмөртэй хашаа, хамгаалалт нь байгалийн тогтоц эсвэл хүний гараар хийгдсэн байж болно.

- 20.2 Зэрлэг, махчин амьтдын эрсдэл байгаа тохиолдолд биет байршил нь мал амьтад руу зэрлэг, махчин амьтад дайрч, гэмтээх эрсдэлийг бууруулах арга хэмжээ **авна**.
- 20.3 Биет байршил нь төллөх дөхсөн, өвчтэй эсвэл гэмтсэн малыг эх сүргээс нь болон бие биеэс нь тусгаарлах боломж, чадамжтай **байх**.
- 20.4 Биет байршил нь төллөх дөхсөн эх малыг саравчинд **байлгана**.

21. Тээвэрлэлт

- 21.1 Биет байршил нь өвчтэй, бэртэж гэмтсэн, нэмэлт тусламжгүйгээр өөрөө зогсох чадваргүй, хээл тээх сүүлийн хоёр сард байгаа эх мал, хүй нь эдгээгүй төл мал эсвэл тээвэрлэх явцад эрсдэлтэй малыг эмнэлгийн тусламж авахаар тээвэрлэхээс бусад тохиолдолд тээвэрлэхгүй **байх**.
- 21.2 Биет байршил нь малыг хөлөөр нь туухдаа ширүүн тууж цуцааж, ядраахгүй хурдыг нь **тохируулна**.
- 21.3 Биет байршил нь малыг тээвэрлэхдээ халуун эсвэл хүйтнээс үйлдэлтэй хямралд оруулахгүй байх нөхцөлийг **бүрдүүлнэ**.
- *Халууны стресс буюу хямрал нь мал биеийн илүүдэл дулаанаа гадагшлуулж чадахгүй үед үүсдэг. Энэ үед малын биеийн температур өсөж зүрхний цохилт нэмэгддэг.*
 - *Хүйтний стресс буюу хямрал нь мал биеийн хэвийн температур дулаанаа хадгалах боломжгүй болж бие хөрсөн үед үүсдэг.*
 - *Малыг эдгээр хямралаас хамгаалснаар хэт халууцах болон хэт хөрөх нөхцөл үүсэхгүй байна гэсэн үг.*
- 21.4 Биет байршил нь тээврийн хэрэгслээр малыг тээвэрлэх бол тээврийн хэрэгслийн дээврийг мал зогсох болон хэвтэхэд толгойд нь хүрэхээргүй хангалттай өндөрт **байлгана**.
- 21.5 Биет байршил нь малыг тээвэрлэхээр ачихаас өмнөх хоёр цагийн туршид тохирох шим тэжээл өгч, усаар ундаалсан байх **ёстой**.
- 21.6 8 цагаас дээш хугацаатай тээвэрлэлтийн үед малд хамгийн багадаа 8 цаг тутамд ус, идэш тэжээл өгч, амраах **ёстой**. Мөн аяллыг үргэлжлүүлэхээс өмнө хамгийн багадаа 8 цагийн турш тээвэрлэж яваа хэрэгслээс буулгаж, хангалттай зай талбайд тааваар нь байлгах.
- *Энэ хугацаанд мал ханатлаа идэж, ундаалсан байх ёстой.*
 - *Ноолуурын ямааны хувьд ямаа бүрд оногдох зай талбай 5м.кв байна.*

22. Аюултай химийн бодисууд

- 22.1 Биет байршил нь малыг хортой химийн бодист хордохгүй байх нөхцөлөөр **хангана**.

23. Үржүүлэг

- 23.1 Биет байршил нь малыг үржүүлэгт сонгохдоо малын эрүүл мэнд, тавлаг байдал болон тухайн бүс нутгийн байгаль орчинд тохирсон байдлыг харгалзан **үзнэ**.
- *Биет байршил нь үржлийн стратеги төлөвлөгөөгөө тайлбарлах чадвартай байх ёстой ба ямаа нь хөл, туурай, шүд зэрэгт генетикийн согоггүй байх ёстой. Мөн ямааны биеийн онцлог нь бүс нутаг, хүрээлэн буй орчиндоо тохирсон байхаас гадна төллөх үед хүндрэлгүй, өвчлөлд өртөмтгүй байх.*
- 23.2 Биет байршил нь хэт бага настай малыг үржүүлэгт оруулахгүй **байх**.
- *Ноолуурын ямааны хувьд хэт бага настай гэдэгт эм төл 12 сараас доош, эр төл 18 сараас доош настай байхыг хэлнэ.*
- 23.3 Биет байршил нь хээл тээх малыг хэт ойр үржилд оруулахгүй байхад анхаарах **ёстой**.

-  *Ноолуурын ямааны хувьд хэт ойр гэдэгт 10 сар тутамд үржилд орохыг хэлнэ.*
- 23.4 Биет байршил нь малыг үржүүлэгт оруулахдаа сүргийн хүйсийн харьцаа нь эцэг малын үржлийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад анхаарна.
-  *Энэ нь эцэг малд ногдох эм малын тоо нь эцэг малын насанд зохицохуйц байх ёстой гэсэн үг.*
- 23.5 Биет байршил нь зохиомол хээлтүүлэг хийлгэхэд дараахын алийг нь ч ашиглах **ёсгүй**:
- a) мэс засал;
 - b) өндгөн эсийг авах;
 - c) үр хөврөл шилжүүлэх;
 - d) төхөөрөмж ашиглан эр бэлгийн эс гарган авах (electro-ejaculation).
- 23.6 Аж ахуйн нэгж нь колони буюу хувилах аргаар гаргасан, гений инженерчлэл ашигласан ба/эсвэл гений засвар хийгдсэн мал аль нэг биет байршлын эзэмшилд байхгүй гэдгийг баталгаажуулах **ёстой**.
- 24. Төл авах, бойжуулах**
- 24.1 Биет байршил нь зөвтгөх үндэслэл, шалтгаангүйгээр кесар хагалгаа **хийхгүй**.
- 24.2 Биет байршил нь зөвхөн цэвэрхэн, зориулалтын багаж, хэрэгсэл ашиглан кесар хагалгааг хийх бөгөөд мэс заслын дараа малын эрүүл мэнд, эдгэрэлтэд анхаарч, **тордоно**.
- 24.3 Биет байршил нь урьдаас төлөвлөсөн кесар хагалгааг зөвхөн малын эмчээр **хийлгэнэ**.
-  *Яаралтай кесар хагалгаа хийлгэхгүй бол эх мал эсвэл төлийн амь насанд эрсдэл учруулж болзошгүй тохиолдолд хагалгааг зөвхөн ур чадвартай, туршлагатай хүнээр хийлгэж болно.*
- 24.4 Биет байршил нь шинээр мэндэлсэн төлийг хангалттай дулаан, цэвэр, хуурай газарт **байлгана**.
- 24.5 Биет байршил нь шинээр мэндэлсэн төлд эхтэйгээ хамт байх болон сүрэгт дасах боломж **бүрдүүлнэ**.
- 24.6 Биет байршил нь яаралтай үед хэрэглэх уургийн хангалттай нөөц **байна**.
-  *Энэ нь төллөх үе эхлэхээс өмнө хангалттай хэмжээний нөөц бэлдсэн байх ёстой гэсэн үг.*
-  *“Хангалттай” гэдэг нь төллөх ямааны тооноос хамаарна.*
- 24.7 Биет байршил нь дөнгөж хүлээж авсан төлийг төрснөөс хойш 24 цагийн дотор өөрөөр нь эсвэл хүний тусламжтайгаар уургаар хангалттай хооллох **ёстой** бөгөөд анхны хооллолт нь төрснөөс хойш 2 цагийн дотор **байна**.
- 24.8 Биет байршил нь төлийг хүний тусламжтай хооллохдоо цэвэр, зөв хадгалсан угж хэрэгслийг **ашиглана**.
- 24.9 Биет байршил нь дөнгөж төрсөн төлийг хангалттай том болох хүртэл нь сүүнээс гаргахгүй **байх**.

- Ноолуурын ямааны хувьд төрөөд 16 долоо хоног болсон эсвэл наанадаж нас биед гүйцсэн хамааны жингийн 40 хувьтай тэнцэх жинтэй болсон тохиолдолд хангалттай том гэдэгт тооцогдоно.
- 24.10 Биет байршил нь хангалттай сүүндээ цадахгүй байгаа төлийг хангалттай том болох хүртэл нь **хооллож** эсвэл өөр эхэд **амлуулна**.
- Ноолуурын ямааны хувьд төрөөд 16 долоо хоног болсон эсвэл наанадаж нас биед гүйцсэн хамааны жингийн 40 хувьтай тэнцэх жинтэй болсон тохиолдолд хангалттай том гэдэгт тооцогдоно.
- 24.11 Төл төллөх цагаар тухайн биет байршилд мал төллүүлэх, төл авах туршлагатай болон төллөх үед тохиолддог нийтлэг асуудлуудыг сайн мэддэг, төллөх үед хүний туслалцаа хэрэгтэй байгаа эсэхийг тодорхойлох, хэзээ малын эмчийн туслалцаа авах талаар мэддэг дор хаяж нэг хүн **байна**.
- 25. Ажил, уналга, эдэлгээний мал**
- Ажил, уналга, эдэлгээний мал гэдэгт гол төлөв нохойг авч үздэг боловч ноос ноолуурын үйлдвэрлэлийн тухайд ямар ч мал амьтныг хамааруулж болно.
- 25.1 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг өдөр бүр хангалттай хэмжээний шим тэжээл, усаар **хангана**.
- 25.2 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малд шаардлагатай үеийн эмчилгээ, арчилгааг түргэн шуурхай **үзүүлнэ**.
- 25.3 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малтай ямар нэг гэмтэл, айдас, дарамт учруулахгүйгээр **харьцана**.
- 25.4 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг байнга уяатай байлгах эсвэл амьсгалыг нь боогдуулахаар уяхыг **хориглоно**.
- Татагдах тусам чангарч зангирдаг гинж ашиглахыг хориглоно.
- 25.5 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг гэмтээж зэрэмдэглэхгүй **байх**.
- Үүнд нохойны шүд, сарвуу, эсвэл сүүлийг авах, тастах хамаарна.
- 25.6 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг зохих вакцинжуулалтад хамруулж, шимэгчтэй тэмцэхэд **анхаарна**.
- 25.7 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг бетон эсвэл төмөр материалтай биш, дулаан, хуурай унтах талбайгаар **хангана**.
- Биет байршил нь цаг агаарын тааламжгүй нөхцөлд ажил, уналга, эдэлгээний малыг хэрхэн арчлах, тэдгээрт хэрхэн анхаарал хандуулахаа тодорхой тайлбарлана.
- 25.8 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний малыг арчлахад хангалттай хүрэлцээтэй, тохиромжтой анхны тусламжийн хайрцагтай **байна**.
- 25.9 Биет байршил нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтад нь бусад мал, амьтдыг тэр дундаа ноос ноолуурын малыг гэмтээхгүй, айлгахгүй, өвтгөхгүй байх нөхцөлөөр **хангана**.

Ноос ноолуурын чанарын сайжруулалт

26. Үржүүлэг

26.1 Биет байршил нь малыг үржүүлэгт сонгохдоо ноос ноолуурын урт, ширхэглэг байдал болон өнгийг харгалзан **үзнэ**.

26.2 Аж ахуйн нэгж нь биет байршлынхаа ноос ноолуурын урт, ширхэглэг байдал, өнгийг сайжруулах үүднээс малынхаа үүлдэр, үржлийг сайжруулах төлөвлөгөө гаргаж **болно**.

26.3 Аж ахуйн нэгж нь өөрийн үйлдвэрлэдэг ноос ноолуурын урт, ширхэглэг байдал, өнгийг хянаж, жил тутамд шалгалт үнэлгээ хийж **болно**.

 Энэ нь олж авсан сургамж, мэдлэгээ нэгтгэх, малын үүлдэр, үржлийг сайжруулах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах боломж юм.

26.3.1 Ноос ноолуурын чанарт ямар нэг асуудал илэрсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь тухайн асуудлын учир шалтгааныг ойлгож, шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч **болно**.

 Тогтмол сайжруулалтын мониторинг хийх зорилгоор ноос ноолуурын чанарыг шалгах, үнэлэх, мөн хэвийн бус зүйл ажиглагдсан тохиолдолд шийдвэрлэх арга хэмжээ авах нь нэг сайжруулах үзүүлэлтэд тооцогдоно.



Нийтэлсэн:

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (ТННЭ)

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах веб хуудас <http://sustainablefibre.org> болон info@sustainablefibre.org мэйл хаягаас авна уу.